

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Илчлэг шивээ ОНӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

᠒᠐2᠖.᠐3.13 № 51
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “ИЛЧЛЭГ
ШИВЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
С.ОТГОНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ -ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4226050339

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
А	Б	1	2
1.1.1	Мөнгөн хөрөнгө	13,248,497.08	4,150,432.03
1.1.2	Дансны авлага	52,806,267.70	70,247,624.13
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	5,370,932.22
1.1.6	Бараа материал	139,578,675.14	142,995,803.38
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	205,633,439.92	222,764,791.77
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,637,228,003.08	2,564,318,194.45
1.2.2	Биет бус хөрөнгө	37,777,525.17	38,868,434.13
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,675,005,528.24	2,603,186,628.58
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,880,638,968.16	2,825,951,420.34
2.1.1.1	Дансны өглөг	3,698,829.16	6,637,523.32
2.1.1.3	Татварын өр	12,631,463.02	32,853,695.42
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	0.03
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	16,330,292.17	39,491,218.76
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,889,775,562.55	1,792,750,441.05
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,889,775,562.55	1,792,750,441.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,906,105,854.72	1,832,241,659.81
2.3.1	Өмч: а) төрийн	2,337,169,892.00	2,337,169,892.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	754,897,865.25	754,897,865.25
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	(2,117,534,643.81)	(2,098,357,996.72)
2.3.11	Эздийн өмчийн дүн	974,533,113.44	993,709,760.53
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,880,638,968.16	2,825,951,420.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ДҮН	ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮН
А	Б	1	2
1	Борлуулалтын орлого (цэвэр)	927,908,972.18	970,937,213.30
2	Борлуулалтын өртөг	912,187,926.82	1,022,455,260.35
3	Нийт ашиг (алдагдал)	15,721,045.36	(51,518,047.04)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	7,539.29
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	286,338,331.68	283,190,313.80
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	11,555,200.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	216,278,798.58	197,967,220.39
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,983,600.00	850,000.00

13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(69,284,801.55)	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	14,512,176.92	21,307,385.65
19	Орлогын татварын зардал	1,451,217.69	2,130,738.56
20	Татварын дараах ашиг (алдагдал)	13,060,959.23	19,176,647.09
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	13,060,959.23	19,176,647.09
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	13,060,959.23	19,176,647.09
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ДҮН	ТАЙЛАНТ ЖИЛИЙН ДҮН
А	Б	1	2
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	864,767,772.93	849,688,648.49
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	856,615,128.61	847,549,648.49
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	162,339.00	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	7,990,305.32	2,139,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	926,262,981.54	859,605,832.83
	Ажиллагчдад олгосон мөнгө	344,256,131.00	366,444,072.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	112,043,148.88	104,093,394.50
	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	323,497,898.28	286,338,077.26
	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	-	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	-	-
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	71,283,574.07	27,092,877.07
	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,401,600.00	963,600.00
	Бусад мөнгөн зарлага	73,780,629.31	74,673,812.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,495,208.61)	(9,917,184.34)

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	7,539.29
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	-	7,539.29
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	7,539.29
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
	Бусад орлого	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
	Бусад зарлага	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(61,495,208.61)	(9,909,645.05)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	73,342,105.69	13,248,497.08
6	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,248,497.08	4,150,432.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	2,337,169,892.00	-	-	754,897,865.25	-	-	(2,130,595,603.04)	961,472,154.21
3	Залруулсан үлдэгдэл	2,337,169,892.00	-	-	754,897,865.25	-	-	(2,130,595,603.04)	961,472,154.21
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,337,169,892.00	-	-	754,897,865.25	-	-	(2,117,534,643.81)	974,533,113.44
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	2,337,169,892.00	-	-	754,897,865.25	-	-	(2,117,534,643.81)	974,533,113.44
12	Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	-	-	-	-	19,176,647.09	19,176,647.09
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,337,169,892.00	-	-	754,897,865.25	-	-	(2,098,357,996.72)	993,709,760.53

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Эдийн засгийн үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нийт орлого	1,544,864.0	1,254,134.9	
2	Нийт зарлага	1,655,054.1	1,232,827.7	
3	Үүнээс:Цалингийн сан	644,535.1	484,990.9	
4	Элэгдлийн зардал	249,241.2	281,275.6	
5	Нийт ашиг	(110,190.1)	21,307.2	
6	Цэвэр ашиг	139,051.1	302,582.8	
7	Батлагдсан орон тоо	37	28	

3. Аудитын илрүүлэлт:

Завсрын аудитаар:

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, бараа материал, үндсэн хөрөнгө, зардлын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 19,160.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан.

3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтыг зөрчиж, Шивээговь-Чойр-Шивээговь маршрутаар ажилчид хүргэж өгөх, авах зорилгоор нийт 5,991.1 мянган төгрөгийн шатахууныг зарцуулж, зардлыг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтуудтай нийцээгүй, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, арвилан хэмнэлттэй, үр ашигтай зардалд зарцуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 44,970.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өглөө.

3.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны бусад цэст хөрөнгө зарцуулахтай холбоотой нийт 4,180.0 мянган төгрөгийн 5 шийдвэр, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт цэст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 3 байгууллагын 66,978.3 мянган төгрөгийн худалдан авалт, худалдан авах ажиллагааны тайланг тус тус мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 95,006.4

мянган төгрөгийн орлогын 7, 10,133.4 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн

Энэ нь Шилэн дансны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, 6.4.8, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.8, 4.1.9, 4.1.10 дахь заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зөрчлийг арилгаж мэдээллүүдийг нөхөн мэдээлэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдээллүүдийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

4. Аудитаар нийт 19,160.0 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс завсрын аудитаар 19,160.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа илрээгүй байна.

Аудитаар нийт 5,347.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 5,347.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,347.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,957.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 2,563.3 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс, 1,180.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1,382.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,563.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13,565.4 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

4.1Төлбөрийн акт

Байхгүй

4.2 Албан шаардлага

Байхгүй

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн хару Илрүүлэлт:

Нийт 6 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулахдаа гарт олгох цалингаас бодож 520.2 мянган төгрөгөөр дутуу суутгасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалтыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сахилгын шийтгэлийн ногдуулалтыг үндсэн цалингаас тооцож суутгах

2. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ус, дулааны авлагын эцсийн үлдэгдлийг анхан шатны баримтуудтай /ААНБ, айл өрхийн 1-12 сарын ус, дулааны бичилт, нэхэмжлэх, борлуулалтын дэвтэр/ тулгахад 3,286.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

1. Нийт 8 ААНБ, айл өрхийн авлагын эхний үлдэгдэл 1,908.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан
2. Нийт 5 ААНБ-ын 831.8 мянган төгрөгийн авлагыг тусгаагүй
3. Нийт 2 ААНБ-ийн авлагыг 199.2 мянган төгрөгөөр илүү тусгасан
4. Нийт 3 ААНБ-ын авлагыг 346.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд тусгагдсан ААНБ, айл өрхийн авлагын үлдэгдлийг борлуулалтын программын авлагын үлдэгдэлтэй тулгаж, авлагын үлдэгдлийг залруулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

3. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайланд 1 албан хаагчийн 1,540.6 мянган төгрөгийн цалинг тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.7 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 39-Ажилтны тэтгэмж, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тайланд 1 албан хаагчийн цалин нөхөж тайлагнах

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
"Илчлэг шивээ" ОНӨААТҮГ	4	19.2	4	19.2	4	19.2						

Дүн	4	19.2	4	19.2	4	19.2						
-----	---	------	---	------	---	------	--	--	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ	4	11.3			1	6.0	3	5.3				
Дүн	4	11.3			1	6.0	3	5.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ	1	71.2			1	71.2		
Дүн	1	71.2			1	71.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ								
Дүн								
Нийт дүн	1	71.2			1	71.2		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨҮГ	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			